



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын Гүн галуутай сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 05 дүгээр сарын 30-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 28,767,674.26 (хорин найман сая долоон зуун жаран долоон мянга зургаан зуун далан дөрвөн төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Гүн галуутай сургууль (Б.Алтансарнай)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 11332 ширхэг нийт 28,767,674.26 (хорин найман сая долоон зуун жаран долоон мянга зургаан зуун далан дөрвөн төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Гүн галуутай сургууль (Б.Алтансарнай)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 06 -ны өдрийн /11.Х. дугаар албан бичгийн хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Гүн галуутай сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нөгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүнгээрт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ийн мөргөжилт-ний дүнгээрт	ЭБХХК-н шийдвэр
1	Ном сурах бичиг	2-8 жил	ш	11332		28,767,674.26	-	-	номын агуулга өөрчлөгдсөн	устгах	устгах	устгах	
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн			11332		28,767,674.26							
	Үүнээс Худалдах хөрөнгө												
	Устгах хөрөнгө												
	Татан төвлөрүүлэх хөрөнгө												
	Худалдсанаас олох орлого												
	НӨХГ-т төвлөрүүлэх /30%/												